ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.04.22 № 459

танай 2025.04.16-ны № 02-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА Б.БОЛДБАЯР
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох Баяндун сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

2125020052

**Дүгнэлт**

Баяндун сумын Монгол ардын намын Баяндун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баяндун сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр нэг хуудас хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

Хавсралт
Баяндун сумын МАН-ын хорооны тэргүүлэгчдийн
хурлын 2025 оны 04 дугаар сарын 13-ны
өдрийн №... тоот тогтоолын хавсралт

# БАЯНДУН СУМААС АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ

1. Спорт заал
2. Малын үүлдэр угсааг сайжруулах
3. Хогийн цэгийг стандартын дагуу болгох ажлыг үргэлжлүүлнэ.
4. Алслагдсан бэлчээрийг усжуулах
5. Зоорь төсөл хэрэгжүүлнэ.
6. Сумын төвийн бетон замын ажлыг үргэлжлүүлнэ.
7. Баян-Уул-Баяндун чиглэлд хатуу хучилттай автозамын ажил эхлүүлнэ. Зураг төсөв хийлгэх.
8. Мах махан бүтээгдэхүүн боловсруулах стандарт үйлдвэр байгуулна
9. Хуурай сүүний үйлдвэрийг ашиглалтанд оруулна
10. Алслагдсан нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлэх
11. Угтамын рашаан сувиллыг дэд бүтцэд холбох
12. Айл өрхүүдийг төвлөрсөн халаалтанд үе шаттайгаар холбоно
13. ЕБС-ийн барилгын их засвар
14. Сумын төвийн ус зайлуулах суваг шуудуу шинээр байгуулах
15. Улз голын төмөр бетон гүүр
16. Соёлын төв, музейн барилга